



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/АБ

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч зах зээл дээрх өвс, тэжээлийн нийлүүлэлт хомс болж онцгой нөхцөл байдал, үүсэж зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлтийг хангах зорилгоор 634 боодол ногоон тэжээлийн нөөц бүрдүүлсүгэй.

2.Нийт 15,368,160 (Арван таван сая гурван зуун жаран найман мянга нэг зуун жаран) төгрөгийг Сумын Мал хамгаалах сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох стандартын шаардлага хангасан тэжээлийг хүлээн авч нөөц бүрдүүлэхийг Тамгын газрын нярав (Б.Баярмаа), Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Б.Баттогтох) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



482401031